



**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН ЯАМ**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Худалдааны гудамж 6/1, Засгийн газрын V байр,
Утас/Факс: (976-51) 26 75 33, E-mail: foreign@mojha.gov.mn,
http://www.mojha.gov.mn

2018.02.28 № 1-4/1014
танай _____-ны № _____-т


**АГЕНТЛАГ, БАЙГУУЛЛАГЫН ДАРГА
НАРТ**

Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах "Салбарын статистик мэдээллийн санг бүрдүүлэх, эрхлэн хөтлөх, ашиглах журам", захиргааны статистик мэдээллийн маягт, түүнийг нөхөх зааврыг Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн А/24 дүгээр тушаалаар баталсныг хавсралтаар хүргүүлж байна.

Энэхүү журмыг мөрдөн салбарын захиргааны статистик мэдээллийг батлагдсан маягтын дагуу гаргаж, журамд заасан хугацаанд тус яамны Хяналт шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газарт ирүүлж байхыг мэдэгдье.

Хавсралт 6. хуудастай.

ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА



Т. БАЯСГАЛАН

Doc ID: 08.0987



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН САЙДЫН ТУШААЛ

2018 оны 02 сарын 13 өдөр

Дугаар А/24

Улаанбаатар хот

Журам, маягт, заавар батлах тухай

Статистикийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.6 дахь хэсэг, 19 дүгээр зүйлийн 19.4 дэх хэсэг, Үндэсний статистикийн хорооны даргын 2018 оны 2 дугаар сарын 2-ны өдрийн А/14 дүгээр тушаалын 2 дахь хэсэг, А/15 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах "Салбарын статистик мэдээллийн санг бүрдүүлэх, эрхлэн хөтлөх, ашиглах журам"-ыг нэгдүгээр хавсралт ёсоор баталсугай.

2. Дор дурдсан захиргааны статистикийн маягт, түүнийг нөхөх зааврыг 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.


- 2.1. Хууль зүйн бүртгэл, зөвшөөрлийн 20 ... оны хагас, бүтэн жилийн мэдээ /З-ХЗБЗ-1/;
- 2.2. Улсын хил хамгаалалт, шалган нэвтрүүлэх ажиллагааны 20 ... оны ...-р сарын мэдээ /З-ХХЕГ-1/;
- 2.3. Гадаадын иргэдийн бүртгэл, хяналтын 20 ... оны ...-р сарын мэдээ /З-ГИХГ-1/;
- 2.4. Иргэний болон хуулийн этгээд, эд хөрөнгө, оюуны өмчийн бүртгэлийн 20 ... оны ...-р сарын мэдээ /З-ОӨУБЕГ-1/;
- 2.5. Архивын бүртгэл, хяналтын 20 ... оны ...-р сарын мэдээ /З-АЕГ-1/;
- 2.6. Криминалистик, шүүх эмнэлэгийн, тусгай болон эдийн засгийн шинжилгээний 20 ... оны ...-р сарын мэдээ /З-ШШҮХ-1/;
- 2.7. Хууль сахиулах сургалтын үйл ажиллагааны 20 ... оны хагас, бүтэн жилийн мэдээ /З-ХСС-1/;
- 2.8. Төрийн тусгай албан хаагчдад үзүүлсэн тусламж, үйлчилгээний 20 ... оны ...-р сарын мэдээ /З-ТТАНЭ-1/;
- 2.9. Хууль зүйн сургалт, сурталчилгаа болон судалгааны ажлын 20 ... оны хагас, бүтэн жилийн мэдээ /З-ХЗҮХ-1/;
- 2.10. Төлбөрийн чадваргүй иргэдэд үзүүлэх хууль зүйн туслалцааны ажлын 20 ... оны ...-р сарын мэдээ /З-ХЗТТ-1/;
- 2.11. Шийдвэр гүйцэтгэх албаны ажиллагаанд байгаа гүйцэтгэх баримт бичгийн 20 ... оны ...-р сарын мэдээ /З-ШГА-1, 3-ШГА-1.1/;
- 2.12. Хүүхдийн тэтгэлгийн төлбөр барагдуулалтын гүйцэтгэх бариимт бичгийн 20 ... оны ...-р сарын мэдээ /З-ШГА-2/;
- 2.13. Түдгэлзүүлсэн, сэргээсэн гүйцэтгэх баримт бичгийн 20 ... оны ...-р сарын мэдээ /З-ШГА-3, 3-ШГА-3.1/;

08 0117

- 2.14. Мөнгөн дүнгийн нэхэмжлэлтэй гүйцэтгэх баримт бичгийн 20 ... оны ...-р сарын мэдээ /3-ШГА-4/;
- 2.15. Төсөвт байгууллагад холбогдох гүйцэтгэх баримт бичгийн 20 ... оны ...-р сарын мэдээ /3-ШГА-5/;
- 2.16. Хорих ял эдэлж буй төлбөр төлөгчийн гүйцэтгэх баримт бичгийн 20 ... оны ...-р сарын мэдээ /3-ШГА-6/;
- 2.17. Малын хулгайн гэмт хэргийн гүйцэтгэх баримт бичгийн 20 ... оны ...-р сарын мэдээ /3-ШГА-7/;
- 2.18. Татан буугдсан, дампуурсан банкны нэхэмжлэлтэй гүйцэтгэх баримт бичгийн 20 ... оны ...-р сарын мэдээ /3-ШГА-8/;
- 2.19. Татан буугдсан, дампуурсан хадгаламж зээлийн хоршооны нэхэмжлэлтэй гүйцэтгэх баримт бичгийн 20 ... оны ...-р сарын мэдээ /3-ШГА-8.1/;
- 2.20. Шүүхээс гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах шүүгчийн захирамжийн 20 ... оны ...-р сарын мэдээ /3-ШГА-9/;
- 2.21. Торгох ялын 20 ... оны ...-р сарын мэдээ /3-ХӨТЯ-1/;
- 2.22. Нийтэд тустай ажил хийлгэх ялын 20 ... оны ...-р сарын мэдээ /3-ХӨТЯ-2/;
- 2.23. Эрх хасах ялын 20 ... оны ...-р сарын мэдээ /3-ХӨТЯ-3/;
- 2.24. Зорчих эрхийг хязгаарлах ялын 20 ... оны ...-р сарын мэдээ /3-ХӨТЯ-4/;
- 2.25. Хуулийн этгээдэд оногдуулсан торгох ялын 20 ... оны ...-р сарын мэдээ /3-ХӨТЯ-5/;
- 2.26. Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авсан шүүхийн шийтгэх тогтоолын биелэлтийн 20 ... оны ...-р сарын мэдээ /3-ХӨТЯ-6/;
- 2.27. Хорих ял оногдуулахгүйгээр тэнссэн, хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолыг биелүүлэхийг хойшлуулсан болон хорих ялаас хугацаанаас өмнө суллаж, хяналт тогтоосон этгээдийн 20 ... оны ...-р сарын мэдээ /3-ХӨТЯ-7/;
- 2.28. Хөрөнгө, орлогыг хураах албадлагын арга хэмжээ авсан шүүхийн шийтгэх тогтоолын биелэлтийн 20 ... оны ...-р сарын мэдээ /3-ХӨТЯ-8/;
- 2.29. Хуулийн этгээдэд эрх хасах, татан буулгах албадлагын арга хэмжээ авсан шүүхийн шийтгэх тогтоолын биелэлтийн 20 ... оны ...-р сарын мэдээ /3-ХӨТЯ-9/;
- 2.30. Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ авсан шүүхийн шийтгэх тогтоолын биелэлтийн 20 ... оны ...-р сарын мэдээ /3-ХӨТЯ-10/;
- 2.31. Үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээ авсан шүүхийн шийтгэх тогтоолын биелэлтийн 20 ... оны ...-р сарын мэдээ /3-ХӨТЯ-11/;
- 2.32. Хоригдлын хөдөлгөөний 20 ... оны ...-р сарын мэдээ /3-ХЯЭ-1/;
- 2.33. Цагдан хорих байрны шүүгдэгчийн 20 ... оны ...-р сарын мэдээ /3-ХЯЭ-2/;
- 2.34. Баривчлах байрны сэжигтний 20 ... оны ...-р сарын мэдээ /3-ХЯЭ-3/;
- 2.35. Цагдан хорих байрны яллагдагчийн 20 ... оны ...-р сарын мэдээ /3-ХЯЭ-4/;
- 2.36. Хоригдлын 20 ... оны жилийн эцсийн дэлгэрэнгүй мэдээ /3-ХЯЭ-5/.

3. Энэхүү журмыг мөрдөж ажиллахыг холбогдох агентлаг, байгууллагын дарга нарт, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /Г.Баясгалан/-д даалгасугай.

4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2010 оны №95, Хууль зүйн сайдын 2014 оны А/48, А/104 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

A square official stamp with a double border. Inside the stamp, there is a handwritten signature in black ink. The signature is stylized and appears to be 'Ц.Нямдорж'. The stamp also contains some faint, illegible text and a small circular emblem in the center.

Ц.НЯМДОРЖ

САЛБАРЫН СТАТИСТИК МЭДЭЭЛЛИЙН САНГ БҮРДҮҮЛЭХ,
ЭРХЛЭН ХӨТЛӨХ, АШИГЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

УАА 33577
9121817
1116725373

1.1. Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах захиргааны статистик мэдээллийн сан бүрдүүлэх, нэгтгэн боловсруулах, хөтлөх, сангийн мэдээллийг ашиглах, лавлагаа, мэдээлэл өгөхөд энэхүү журмыг дагаж мөрдөнө.

1.2. Салбарын статистик мэдээллийн санг /цаашид "мэдээллийн сан" гэх/ Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах салбарын хэмжээний бодлого төлөвлөлт, шийдвэр гаргах үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар хангах зорилгоор ашиглана.

1.3. Мэдээллийн санд дараах агентлаг, байгууллага энэхүү журмын 2 дугаар хавсралтаар баталсан маягтын дагуу захиргааны статистик мэдээллийг сар тутам гарган нийлүүлнэ /цаашид "нийлүүлэгч" гэх/.

- 1.3.1. Хил хамгаалах ерөнхий газар;
- 1.3.2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар;
- 1.3.3. Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газар;
- 1.3.4. Гадаадын иргэн, харьяатын газар;
- 1.3.5. Архивын ерөнхий газар;
- 1.3.6. Шүүх шинжилгээний үндэсний хүрээлэн;
- 1.3.7. Хууль зүйн туслалцааны төв;
- 1.3.8. Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэг.

1.4. Мэдээллийн санд дараах байгууллага, нэгж энэхүү журмын 2 дугаар хавсралтаар баталсан маягтын дагуу захиргааны статистик мэдээллийг хагас жил тутам гарган нийлүүлнэ.

- 1.4.1. Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газар
- 1.4.2. Хууль зүй, дотоод хэргийн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар;
- 1.4.3. Хууль зүйн үндэсний хүрээлэн;
- 1.4.4. Хууль сахиулахын их сургууль.

1.5. Цагдаагийн ерөнхий газар нь Төрийн нарийн бичгийн даргын 2017 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн А/68 дугаар тушаалаар баталсан маягтын дагуу захиргааны статистик мэдээллийг сар тутам гарган нийлүүлнэ.

1.6. Статистик мэдээллийг бүрдүүлэх, хөтлөх, нэгтгэн боловсруулах, баяжилт хийх, мэдээллийн үнэн зөв байдал, холбогдох албан тушаалтанг лавлагаа, мэдээллээр хангах үүргийг Хяналт шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газрын статистик мэдээллийн сан хариуцсан мэргэжилтэн хариуцна.

Хоёр. Мэдээллийн сангийн мэргэжилтэн болон нийлүүлэгчийн эрх, үүрэг

2.1. Нийлүүлэгчийн эрх, үүрэг:

2.1.1. Статистик мэдээллийг энэхүү журмын 2 дугаар хавсралтаар баталсан үзүүлэлтийн дагуу үнэн зөв гарган энэхүү журмын 1.3, 1.4-т заасан хуваарийн дагуу дараа сарын 5-ны дотор Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт албан бичгээр ирүүлнэ;

2.1.2. Тус яаманд ирүүлсэн мэдээллийн үнэн зөв, алдаагүй байдлыг бүрэн хариуцах;

2.1.3. Хагас жил бүрийн статистик мэдээллийг өмнөх оны мөн үе болон өмнөх сарын үзүүлэлттэй харьцуулалт хийж, өссөн, буурсан шалтгаан нөхцлийн талаар салбарын бодлого шийдвэртэй уялдуулан дүн шинжилгээ хийж, танилцуулгыг бэлтгэн хавсарган ирүүлэх;

2.1.4. Мэдээллийн санд шинээр үзүүлэлт нэмж оруулах, хасах асуудлаар тухай бүр санал гарган яамны мэдээллийн сан хариуцсан мэргэжилтнээр уламжлуулан шийдвэрлүүлэх.

2.1.5. Статистик мэдээллийн нууцыг задруулахгүй байхыг холбогдох этгээдээс шаардах.

2.2. Мэдээллийн сангийн мэргэжилтний эрх, үүрэг:

2.2.1. Сар бүрийн статистик мэдээллийг энэхүү журмын хавсралтаар баталсан үзүүлэлт болон бусад хууль тогтоомжийн дагуу гаргуулж авах;

2.2.2. Статистик мэдээллийг ашиглах, хэвлэн нийтлэхдээ нийлүүлэгчийн нэрийг заавал заах;

2.2.3. Нийлүүлэгчээс ирүүлсэн статистик мэдээллийг хүлээн авч нягтлан, төрөлжүүлэн ангилж, нэгдсэн санд төвлөрүүлэн цаасан болон цахим хэлбэрээр архивын нэгж болгон хадгалах;

2.2.4. Нийлүүлэгчээс ирүүлсэн сар бүрийн мэдээллийг энэхүү журмын 3 дугаар хавсралтын дагуу нэгтгэн дараа сарын 10-ны дотор Сайд, Дэд сайд, Төрийн нарийн бичгийн даргад танилцуулах;

2.2.5. Нийлүүлэгчээс ирүүлсэн мэдээллийн алдаа, хугацаа хожимдол, таслалтад хяналт тавих.

2.2.6. Нийлүүлэгчээс мэдээллийг журамд заасан хугацаанд мэдээллийн санд ирүүлэн, цахим хуудаст байршуулж байхыг шаардах;

2.2.7. Байгууллагын нууцтай холбоотой мэдээллийг задруулахгүй байх;

2.2.8. Нийлүүлэгчээс хагас жил бүр ирүүлж буй танилцуулгыг нэгтгэн удирдлагад танилцуулах;

2.2.9. Төлбөрийн чадваргүй иргэдэд үзүүлэх хууль зүйн туслалцааны жилийн эцсийн мэдээг жил бүрийн 1 дүгээр сарын 20-ны дотор Үндэсний статистикийн хороонд албан бичгээр хүргүүлэх.

2.2.10. Мэдээллийн санд шинээр үзүүлэлт нэмж оруулах, хасах асуудлаар тухайн агентлаг, байгууллагатай хамтран санал боловсруулан шийдвэрлүүлэх, хэрэгжилтэд нь хяналт тавих.

Гурав. Хэрэгжилтэд хяналт тавих

3.1. Энэхүү журмын хэрэгжилтэд Хууль зүй, дотоод хэргийн яамны Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар хяналт тавьж, нийлүүлэгчийг мэргэжил, арга зүйн удирдлагаар ханган ажиллана.

3.2. Мэдээлэл нийлүүлэгч нь статистик мэдээлэл ирүүлэх хугацаа хожимдуулсан, алдаатай мэдээлэл ирүүлсэн тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээнэ.

-----oO-----